



## ОРОН НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ: ТӨВ АЙМГИЙН ЗААМАР, СЭРГЭЛЭН СУМДАД

### МОНИТОРИНГИЙН ТУХАЙ

Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн ТТБ-ын Төв аймаг дахь салбар нь Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгтэйгээр 2020 онд нутгийн захиргааны байгууллага, уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд байгуулагддаг хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд мониторинг хийв. Энэхүү мониторингийн зорилго нь гэрээний хэрэгжилтийг хөндлөнгөөс үнэлэх замаар орон нутгийн хөгжил, ажлын байрыг нэмэгдүүлэхэд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн оруулж буй бодит хувь нэмрийг үнэлэх, цаашид гэрээний хэрэгжилт, үр нөлөө, ил тод байдлыг сайжруулахад хийх алхмуудыг тодорхойлох явдал байлаа. Мониторингийн хүрээнд “Шижир алт”, “Илт гоулд”, “Үүрт гоулд” компаниудаас 2020 онд Төв аймгийн Заамар, Сэргэлэн сумдын захиргаатай байгуулсан гэрээг сонгон авч, хэрэгжилтийг үнэлэв.

Мониторингийн дүнд орон нутгийн гэрээний хэрэгжилт, түүнийг байгуулах, үнэлж дүгнэн нийтэд мэдээлэх үйл явцад гарч буй нийтлэг зөрчлүүдийг тодорхойлж, талуудын хариуцлага, гэрээний ил тод байдлыг хангахтай холбоотой зөвлөмж боловсруулж, мониторингод хамрагдсан сумдын захиргаа болон эдгээр сумдад үйл ажиллагаа явуулж буй компаниудад хүргүүлээ.

### МОНИТОРИНГИЙН ДҮН

#### ГЭРЭЭНИЙ АГУУЛГА, ЧАНАРЫН ТУХАЙД

Хамтран ажиллах гэрээний зорилгыг Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д байгаль орчныг хамгаалах, ажлын байр нэмэгдүүлэх, уурхай байгуулахтай холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх хэмээн тодорхойлсон байдаг. Харин Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолоор батлагдсан “Байгаль орчин хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ”-ний загварт (цаашид Загвар гэрээ гэх) тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ИТХ-аас баталсан тодорхой төсөл арга хэмжээг Засаг даргатай хамтран хэрэгжүүлэх, орон нутгаас уул уурхайн хэрэгцээт бараа, ажил үйлчилгээг нэн тэргүүнд худалдан авах, орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах талаар заасан. Ийм ч учраас уул уурхай бүхий орон нутагт хийгдсэн дийлэнх гэрээнд орон нутгийн хөгжилд хөрөнгө оруулалт хийх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, хандив тусламж үзүүлэх, ажлын байр, бизнесийн боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн тодорхой заалт тусгагдсан байдаг. Гэтэл мониторингод хамрагдсан зарим компани, тухайлбал

“Үүрт гоулд” ХХК-ийн Төв аймгийн Заамар, Сэргэлэн сумуудтай байгуулсан гэрээнд орон нутгийн хөгжлийг дэмжих, ажлын байр бий болгохтой холбоотой заалт огт тусгагдаагүй байна. Энэ нь Ашигт малтмалын тухай хууль, Загвар гэрээнд заасан зорилгыг бүрэн хангаж чадахааргүй байгаа юм.

Мониторингод хамрагдсан гэрээнүүдийн байгаль орчныг хамгаалах үүрэг нь компанийн хуулиар хүлээсэн үүрэгтэй давхардсан буюу тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөхөн сэргээлтийн үүргийг давтсан агуулгатай байна. Ийнхүү компанийн хувьд хуульд зааснаас илүү нэмэгдэл үүрэг хариуцлага хүлээхээргүй байгаа нь орон нутгийн хувьд үр ашиггүй юм.

Гэрээний зарим заалт хэт ерөнхий, бүрхэг байгаагаас түүний хэрэгжилтийг хэмжих боломжгүй байна. Тухайлбал, Заамар сумын “Шижир алт” ХХК-тай байгуулсан гэрээнд заасан нутгийн иргэдийг ажлын байраар хангах, ажлын хувцас худалдан авах үүрэг, “Илт Гоулд” ХХК-ийн гэрээнд тусгасан ажлын байр бий болгох үүрэг нь тодорхой тоо хэмжээ, шалгуур үзүүлэлтгүй байна.

Хамтран ажиллах гэрээ байгуулахад иргэдийн оролцоог хангах, байгуулагдсан гэрээ болон түүний хэрэгжилтийн мэдээллийг нийтэд ил тод болгох нь олон нийтийн хяналтыг бий болгож, гэрээний үр ашгийг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг сайжруулахад чухал үүрэгтэй. Ийм ч учраас Загвар гэрээнд гэрээ байгуулахад иргэдийн төлөөлөл бүхий Хамтын ажиллагааны хороо байгуулах, иргэдийн санал авах хэлэлцүүлэг зохион байгуулах, гэрээ байгуулснаас хойш ажлын 3 хоногийн дотор өөрсдийн цахим хуудсаар нийтэд ил тод болгож, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС)-ын дэд зөвлөлд хүргүүлэх тухай заасан байдаг. Гэтэл мониторингод хамрагдсан дээрх хоёр сумын хамтран ажиллах гэрээнд иргэдийн оролцоог хангах заалт тусгагдаагүй байгаа нь Загвар гэрээний агуулгатай нийцэхгүй байна. Тэрчлэн сумын Засаг даргын Тамгын газрын цахим хуудас болон компанийн цахим хуудсаар дамжуулан гэрээ, түүний хэрэгжилтийг иргэдэд мэдээлэхээр гэрээнд тусгагдсан боловч талууд энэхүү үүргээ хэрэгжүүлээгүй, мэдээллийг цахим хуудсанд байршуулаагүй байна.

## ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, ХЭРЭГЖИЛТИЙГ ДҮГНЭЖ ТАЙЛАГНАХ ҮЙЛ ЯВЦЫН ТУХАЙД

Хамтран ажиллах гэрээ нь төрийн захиргааны байгууллагаас хуульд заасны дагуу нийтийн ашиг сонирхлын төлөө байгуулах Захиргааны гэрээ болохын хувьд гэрээ байгуулахаас өмнө эрх ашиг сонирхол нь хөндөгдөх талуудад мэдээлэл өгч, Сонсох ажиллагаа зохион байгуулах ёстой. Өөрөөр хэлбэл, Захиргааны ерөнхий хуулийн дагуу нутгийн захиргааны байгууллага Сонсох ажиллагаа зохион байгуулах үүрэгтэй. Гэтэл Заамар, Сэргэлэн сумдын захиргаанаас гэрээ байгуулах шатанд иргэдээс санал авахдаа Орон нутгийн хөгжлийн сангийн санал асуулгатай хамтатгасан нь хууль зөрчжээ. Ингэснээр уул уурхайн сөрөг нөлөөлөлд өртөж буй иргэдийн эрх ашгийг хамгаалах асуудал гэрээнд бүрэн тусгагдаж чадахгүйд хүрч байна.

Мөн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр, бараа ажил үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэх, сонгон шалгаруулалтыг нээлттэй зохион байгуулах явдал дээрх сумдад хангалтгүй байв. Энэ нь гэрээгээр бий болсон ажлын байр, бараа бүтээгдэхүүн нийлүүлэх боломжийг иргэд тэгш ашиглах боломж нь буурах төдийгүй гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, шаардлага гаргаж чадахгүйд хүрч байна.

Мониторингод хамрагдсан сумдын аль аль нь цар тахлын улмаас компаниудын үйл ажиллагаа жигдрээгүй гэсэн шалтгаанаар 2020 онд хамтран ажиллах гэрээг дүгнэж, биелэлтийг ИТХ-д тайлагнаж, иргэддээ мэдээлээгүй байна.

## ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТУХАЙД

Заамар сумын тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудтай байгуулсан гэрээнд орон нутагт бүтээн байгуулалт, байгаль орчныг хамгаалж нөхөн сэргээх, иргэдийг ажлын байраар хангах, орлого нэмэгдүүлэх, үйлчилгээг сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээнүүд тусгагдсан байх ба харьцангуй үр дүнтэй хэрэгжсэн байна. Тухайлбал:

- “Шижир алт” алтны үйлдвэр нь гэрээний хүрээнд сум орон нутгийн иргэд, хүүхэд залуучуудын эко орчин, боловсролыг хөгжүүлэх ногоон байгууламж барьжээ. Тэрчлэн байгаль орчныг хамгаалах чиглэлээр 10 га талбайд биологийн нөхөн сэргээлт, 20 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийх үүрэг гэрээгээр хүлээснээс 10 га талбайд биологийн, 29 га талбайд техникийн нөхөн сэргээлт тус тус хийжээ. Тэрчлэн уурхайн хэрэгцээний мах сүү, хүнсний ногооны хангалтыг 100 хувь орон нутгаас хангах үүргийн дагуу нэр бүхий иргэдээс 4631 кг мах, хүнсний ногоог Хайлааст багийн Ундрах дэлгүүрээс худалдан авсан байна.
- 2020 онд сумын ИТХ-ын 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн 36 дугаар тогтоолын дагуу 30 оюутанд нийт 30 сая төгрөгийн сургалтын тэтгэлэг олгожээ.
- “Илт Гоулд” ХХК нь хүүхэд залуучуудын дунд нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх хөл бөмбөгийн талбай байгуулжээ. Байгаль орчныг хамгаалах үүргийн хүрээнд 10.7 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийхээс 7.5 га, 8 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийх байсан ч давуулан биелүүлж 12 га талбайг нөхөн сэргээжээ. Мах сүүний хэрэгцээнд орон нутгаас 15 бод, 20 бог, 3000 л сүү авахаар гэрээнд тусгасны дагуу орон нутгийн 10 малчин өрхөөс нийт 23,213,100 мянган төгрөгийн мах,

сүү; хүнсний ногооны хэрэгцээнд 2 тн төмс, 2 тн хүнсний ногоог Хайлааст багийн төвийн дэлгүүрээс тус тус авч хэрэглэж байна. Түүнчлэн ажлын 60 хос гутал, 30 хос хувцас авахаас 7.45 сая төгрөгийн үнэ бүхий 58 хос гутал орон нутгаас авч хэрэглэжээ.

- Харин “Үүрт гоулд” ХХК-ийн гэрээнд сум орон нутагт хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт хийх талаар тусгаагүй, зөвхөн бүх нийтийн бэлчээрийн хог цэвэрлэгээний ажилд техник хэрэгслээр туслах үүрэг л тусгагджээ. Харин байгаль орчныг хамгаалах чиглэлээр 25 га талбайд нөхөн сэргээлт хийх үүрэг хүлээж, 28.5 га талбайг нөхөн сэргээжээ. Сумын хэмжээнд ажлын байр зарласан боловч иргэд хамрагдаагүй гэсэн тайлбар өгсөн болно.
- Заамар сумын хувьд орон нутгийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг “Заамар нутгийн хөгжлийг дэмжих сан”-аар дамжуулан хэрэгжүүлж байна. “Заамар нутгийн хөгжлийг дэмжих сан” нь жил бүр 13-14 тусгай зөвшөөрөл эзэмшигч компанитай гуравласан гэрээ байгуулан хөрөнгө татаж, орон нутгийн хөгжилд ач холбогдолтой төсөл арга хэмжээг судлан хэрэгжүүлж байна. Тухайлбал, мониторингод хамрагдсан “Илт гоулд” ХХК нь 2020 онд “Заамар нутгийн хөгжлийг дэмжих” сантай гэрээ байгуулж, 100 сая төгрөг төвлөрүүлжээ.

Сэргэлэн сум нь “Үүрт гоулд” ХХК-тай 2020 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр “Байгаль орчныг хамгаалах, уул уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ” байгуулжээ. Гэхдээ тус компани 2020 онд үйл ажиллагаа явуулаагүй тул гэрээний дагуу ямар нэгэн ажил хийгдээгүй, хоёр талаас биелэлтийг нь ч дүгнээгүй ажээ.

1. Төв аймгийн Сэргэлэн, Заамар сумдын удирдлагаас уул уурхайн компаниудтай гэрээ байгуулахдаа түүний агуулга, үр нөлөөг анхаарч, Ашигт малтмалын тухай хууль болон Загвар гэрээнд заасан байгаль орчныг хамгаалах, ажлын байр нэмэгдүүлэх, дэд бүтэц хөгжүүлэх, орон нутгийн тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилгод бүрэн нийцүүлэх;
2. Гэрээний талууд Захиргааны ерөнхий хууль, Загвар гэрээгээр хүлээсэн үүрэг, нийгмийн хариуцлагаа ухамсарлан гэрээ байгуулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг үнэлж дүгнэх үйл явцад иргэдийн хяналт оролцоог хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх. Үүнд:
  - Гэрээ байгуулах шатанд Захиргааны ерөнхий хуулийн дагуу Сонсох ажиллагааг заавал хийж хэвших;
  - Иргэдийн оролцоог хангахад чиглэсэн Загвар гэрээний заалтуудыг гэрээндээ тусган талуудын оролцоо бүхий хамтын ажиллагааны хороо байгуулах замаар гэрээний хэрэгжилтийг хянах, үнэлэх үйл ажиллагаанд иргэд оролцох, хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэх;
- Гэрээний хүрээнд хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөр, ажлын байр, худалдан авалт гэрээний хэрэгжилт, компаниудын байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол тайлагнах, иргэд олон нийтэд тогтмол хүртээмжтэйгээр мэдээлэх;
4. Гэрээний хэрэгжилтийг жил бүр заавал дүгнэн, нутгийн иргэдэд мэдээлж хэвших;
3. Гэрээнд хууль тогтоомжоор хүлээсэн үүргийг давхардуулан тусгахгүй байх;
4. Ажлын байр, бараа ажил үйлчилгээ орон нутгаас авах гэх мэт үүргийг тодорхой болгож, хэрэгжилтийг хэмжих шалгуур тоон үзүүлэлтийг гэрээнд заавал тусгах;
5. Иргэдийн хяналт оролцоотойгоор сумын хөгжил, ирээдүйн сайн сайхны төлөө үйл ажиллагаагаа төлөвлөн хэрэгжүүлэх, “Заамар нутгийн хөгжлийг дэмжих сан”-ийн үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулахад сумын ИТХ-аас удирдлага зохион байгуулалтаар хангаж дэмжиж ажиллах;
6. Сэргэлэн сум нь бусад орон нутгийн сайн туршлагыг судлан хамтран ажиллах гэрээний орон нутгийн хөгжилд оруулах үр нөлөөг нэмэгдүүлэхэд анхаарах.

**МОНИТОРИНГИЙН БАГ:**
**ТӨСЛИЙН УДИРДАГЧ:**

Ц.Батсайхан, Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн ТББ-ын Төв аймаг дахь салбарын зохицуулагч

**БАГИЙН ГИШҮҮН:**

С.Наранцэцэг, эдийн засагч  
Г.Хонгорзул, эрх зүйч

Мониторийг эмхэтгэж бичсэн Д.Эрдэнэчимэг



НЭЭЛТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

Жамьян гүний гудамж-5/1, Сүхбаатар дүүрэг,  
Улаанбаатар-14240

Утас: (976) 76113207

И-мэйл: osf@forum.mn

Вэб: www.forum.mn